



Сүхбаатар аймгийн нийгэм,
эдийн засгийн байдал
2022/03

АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ 2022/03



sukhbaatar.nso.mn

www.nso.mn

www.1212.mn



Хэрэглэгч та Статистикийн
тоон мэдээллийн 1212.mn
аппликейшнаар авна уу.



Хэрэглэгч та өөрийн гар
утаснаас QR code уншуулагч
аппликейшни ашиглан тухай
сарын мэдээллийг авч үзэх.
/интернетэд холбогдсон байх/



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

**СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**

**3 сар
2022**

Баруун-Урт сум



ГАРЧИГ

| | |
|---|-------|
| Ерөнхий тэмдэглэл | 3 |
| Аргачлалын тайлбар | 4-5 |
| Товч танилцуулга | 6-15 |
| Үндсэн үзүүлэлтүүд | 16 |
| I. Нийгмийн үзүүлэлт | |
| I.1 Хөдөлмөр | 17-19 |
| I.2 Нийгмийн даатгал, нийгмийн халамж | 20-21 |
| I.3 Эрүүл мэнд | 22-23 |
| I.4 Соёл, урлаг..... | 24 |
| I.5 Газар өмчлөл | 25 |
| I.6 Гэмт хэрэг | 26-27 |
| II. Эдийн засгийн үзүүлэлт | |
| II.1 Мөнгө, банк, даатгал | 28 |
| II.2 Төрийн санхүү | 29-30 |
| II.3 Үнэ | 31-33 |
| II.4 Хөдөө аж ахуй | 34-37 |
| II.5 Аж үйлдвэр | 38-40 |
| II.6 Тээвэр | 41 |



Ерөнхий тэмдэглэл

I. Товчилсон үгийн тайлал:

Сумдын нэр:

| | |
|---------------|-----------------|
| АС Асгат | ТШ Түвшинширээ |
| БД Баяндэлгэр | ТЦ Түмэнцогт |
| ДА Дарьганга | УБ Уулбаян |
| МХ Мөнххаан | ХА Халзан |
| НА Наран | ЭЦ Эрдэнэцагаан |
| ОН Онгон | БУ Баруун-Урт |
| СҮ Сүхбаатар | |

Төл гэсэн нь төлөвлөгөө, Гүйц гэсэн нь гүйцэтгэл юм.

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V, VI, VII ...г.м)

Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-XI зэргээр илэрхийлэв.

III. Дараах тэмдэглэлийг ашиглав:

| | | |
|----------------------|------|------------------|
| ... Мэдээлэл байхгүй | x | Бүтцийн өөрчлөлт |
| 0.0 Маш бага тоо | +, - | Зөрүү |
| - Гүйцэтгэл байхгүй | * | Дахин |

┌ "Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

IV. 22-21 нь 2021 оны үзүүлэлт тухайн оны үзүүлэлтээс өсч, буурсан абсолют өөрчлөлт.

V. Орон дэвшүүлэхээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас их, бага зэрэг зөрүүтэй байж болно.



АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

- **Хөдөлмөр:** Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн хүмүүс орсон болно.
- **Эрүүл мэнд, Гэмт хэрэг:** Уг салбарын мэдээнүүдийг холбогдох газар, хэлтсүүд нь нэгтгэн гаргаж ирүүлдэг.
 - **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
 - **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
- **Эрүүгийн хуульд** эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нилээд өөрчлөгдсөн.

 - Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүйгээс алах хэргийг нэгтгэн оруулсан.
 - Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.
 - Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдыг эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.
 - Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.
 - 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог оны эхний 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.



- **Хэрэглээний үнийн индекс / ХҮИ / гэдэг нь** хэрэглэгчдийн худалдаж авсан бараа үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.
 - Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.
- **Мөнгө, банк:** Монгол банк арилжааны банкнуудаас мэдээг авч нэгтгэн, банкнуудын үндсэн материалын хамт ирүүлдэг.
- **Төрийн санхүү:** Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймагын төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ. Аймагын нэгдсэн төсөв нь татварын болон татварын бус орлого, улсаас авах санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого, орон нутгийн сангийн орлогын шилжүүлэг зэргээс бүрдэнэ. Төсвийн мэдээг Санхүү төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.
- Аймагын төсвийн мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.
- **Хөдөө аж ахуй:** Газар тариалангийн эцсийн мэдээг багийн Засаг дарга нар өрхөөс цуглуулах ба аж ахуй нэгж байгууллагууд сумын тамгын газарт салбар хариуцсан ажилтанд өгч нэгтгэн ирүүлдэг.
- **Аж үйлдвэр:** Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа Нэгдсэн үндэсний байгууллагын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Үндсэн нэгжүүд мэдээг ирүүлдэг.

Нийт бүтээгдэхүүний өсөлтийг тооцохдоо: гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2010 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.

Борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд оны үнээр үнэлж, худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

Сүхбаатар аймгийн нийгэм, эдийн засгийн байдал


I. Нийгмийн үзүүлэлт



I.1 Хүн ам

Эрүүл мэндийн газраас гаргадаг мэдээгээр эхний 3 сард 230 хүүхэд шинээр мэндэлж 76 хүн нас баржээ. Хүн амын цэвэр өсөлт 154 болсон нь өмнөх оны мөн үеэс 116 (43.0%)-аар буурсан байна. 1000 хүнд ногдох төрөлт 3.6, нас баралт 1.2 пункттэй байна.

Зураг.I.1 Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо



I.2 Хөдөлмөр

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэдийн тоо 2022 оны 1 дүгээр улирлын эцэст 532 болсны 220 (41.4%) нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгэлтэй ажил хайгчдын 430 нь ажилгүй иргэд байгаа нь өмнөх оны мөн үеэс 47 (9.9%) хүнээр, 2021 оны 12 дугаар сарын эцсээс 133 (23.6%) хүнээр тус тус буурсан байна.

Эхний 3 сарын байдлаар Хөдөлмөр халамж, үйлчилгээний газарт 251 ажилгүй иргэн шинээр бүртгүүлсний 22 иргэн ажилд зуучлагдан орсон байна.

Зураг.I.2.1 Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд





Ажилгүй иргэдийн 340 (79.1%) нь 15-44 насныхан эзэлж байгаа юм.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 1 (0.2%) нь магистр, доктор, 69 (16.0%) нь бакалавр, 11 (2.6%) нь тусгай дунд, 25 (5.8%) нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 247 (57.4%) нь бүрэн дунд, 55 (12.8%) нь суурь, 17 (4.0%) нь бага боловсролтой, 5 (1.2%) боловсролгүй хүмүүс байна.

Зураг I.2.2 бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшингээр, эхний 3 сарын байдлаар



Эхний 3 сарын байдлаар 3 шинэ ажлын байр бий болсон нь өмнөх оны мөн үеэс 17 (85.0%)-аар буурчээ. Шинэ ажлын байрыг ангилалаар нь авч үзвэл үйлчилгээний бусад салбарт 3 ажлын байр гарсан байна.



I.3 Нийгмийн даатгал, халамж:

Нийгмийн даатгалын шимтгэлийн нийт орлого 4.2 тэрбум төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 0.5 (12.3%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Аймгийн хэмжээнд сайн дурын даатгуулагчид 0.4 тэрбум төгрөгийн шимтгэл төлж, өмнөх онтой харьцуулахад 0.1 тэрбум (49.6%) төгрөгөөр өсжээ.

2022 оны 1-р улирлын байдлаар нийгмийн даатгалын сангаас нийт 9.3 мянган иргэнд 19.2 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосноос, 7.2 мянган өндөр настанд 14.8 тэрбум төгрөг, 1.3 мянган тахир дутуу иргэнд 2.3 тэрбум төгрөг, 0.4 мянган тэжээгчээ алдсан иргэнд 0.7 тэрбум төгрөг, 0.4 мянган иргэнд цэргийн тэтгэвэрт 1.3 тэрбум төгрөг, үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчтөний даатгалаас 0.03 мянган иргэнд 0.1 тэрбум төгрөгийг тус тус бүрэн олгосон байна.

Нийт тэтгэвэр авагчдын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 223 (2.4%) хүнээр, олгосон тэтгэврийн хэмжээ 9.1 (89.2%) тэрбум төгрөгөөр тус тус өсжээ.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр эхний 3 сард 22.8 мянган иргэнд 3.3 тэрбум төгрөгийн хөнгөлөлт, тусламж, дэмжлэгийг олгосон байна. Үүнийг төрлөөр нь авч үзвэл: Улсын төсвөөс нийгмийн халамжийн тэтгэврийг 1.2 мянган иргэнд 1.1 тэрбум төгрөг, нийгмийн халамжийн тэтгэмжийг



0.9 мянган иргэнд 0.3 тэрбум төгрөг, бусад хөнгөлөлт, тусламж, дэмжлэгт 14.6 мянган иргэнд 1.0 тэрбум төгрөгийг, орон нутгийн төсвөөс 0.9 мянган иргэнд 0.3 тэрбум төгрөгийг, цахим системээр эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжийг 4.1 мянган иргэнд 0.6 тэрбум төгрөгийг тус тус олгожээ.




I.4 Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд 1-р улирлын байдлаар 58.6 мянган хүнд үзлэг хийсэн нь урьд оны мөн үеэс 1.7 (3.0%) мянган хүнээр өсч, 4.1 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн байна. Урьдчилан сэргийлэх үзлэгт 11.4 мянган хүн хамрагдсан нь урьд оны мөн үеэс 4.5 (28.3%) мянган хүнээр буурсан.

Түргэн тусламжийн дуудлага 4.4 мянган удаа гарсны 0.8 (17.6%) мянга нь алсын дуудлага байгаа нь урьд оны мөн үеэс 45 (5.4%) удаагийн дуудлагаар буурсан байна.

Аймгийн хэмжээнд 230 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 230 болж, урьд оны мөн үеэс амаржсан эхийн тоо 124 (35.0%), хүүхдийн тоо 126 (35.4%)-аар тус тус буурсан байна.

Зураг.I.4. Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо



Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 2022 оны эхний 3 сарын байдлаар 3.5 мянган болж өмнөх оны мөн үеэс 3.3 мянга (25.2 дахин) тохиолдлоор өсөхөд коронавирус /ковид-19/ халдвар 3.4 мянгаар нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.




I.5 Соёл, урлаг:


Хөгжимд жүжгийн театр: 2.9 мянган үзэгчдэд 8 удаа тоглолтоор үйлчилж, 3.5 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс тоглолтын тоо 4 (2 дахин), танхимын үзэгчдийн тоо 2.3 мянга (4.8 дахин)-аар өссөн.



Зураг I.5.1 Нийт тоглолтын тоо




Зураг I.5.2 Нийт үзэгчдийн тоо, мян.хүн




Музей: 2022 оны 1-р улиралд 1.2 мянган хүнд 2.3 мянган үзмэрээр үйлчилж, 0.8 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад үзмэрийн тоо 29 (1.3%)-оор өсч нэмэгджээ.

Зураг I.5.3 Нийт үзмэрийн тоо




Зураг I.5.4 Нийт үзэгчдийн тоо, мян.хүн




Номын сан: Нийт 49.2 мянган номоор 1.4 мянган уншигчдад үйлчилжээ. Өмнөх оны мөн үеэс номын тоо 0.4 (0.8%) мянгаар өсч, уншигчдын тоо 0.7 мянган (2 дахин) хүнээр өсчээ.

Зураг I.5.5 Нийт номын тоо



Зураг I.5.6 Нийт уншигчдын тоо, мян.хүн



I.6 Газар өмчлөл:

Аймгийн хэмжээнд 1 дүгээр улирлын байдлаар газар өмчлүүлэх шийдвэр гараагүй байна.



I.7 Гэмт хэрэг

Бүртгэгдсэн гэмт хэрэг 2022 оны 3 сард 175 болж, өмнөх оноос 66 (60.6%)-аар өсчээ.




Бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 4 хүн нас барж, 30 хүн гэмтэж бэртсэн бөгөөд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 737.5 сая төгрөгийн хохирол учирсны 41.9 хувийг нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 122 хүн холбогдон сэжиглэгдсэний 39 (32.0%) хүн нь согтуугаар хэрэг үйлджээ.

Нийт 99 хүн эрүүлжигдсэн нь өмнөх оны мөн үеэс 24 (19.5%) хүнээр буурсан байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 20 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авахуулсан байна.

Аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 25.3 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 9.0 пунктээр буурсан байна.

Зураг.I.7.1 Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо



II. Эдийн засгийн үзүүлэлт



II.1 Мөнгө, банк:

Монгол банкны мэдээллээр ХААН, Төрийн, Хас, Голомт банкнуудаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 192.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх сараас 3.5 (1.9%) тэрбум, өмнөх оны мөн үеэс 52.2 (33.8%) тэрбум төгрөгөөр тус тус өсжээ.

Банкнуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 146.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх сараас 14.8 (11.2%) тэрбум, өмнөх оны мөн үеэс 9.9 (7.2%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Нийт хадгаламжийн 83.5% нь хугацаатай, 16.5 % нь хугацаагүй хадгаламж байна.

Чанаргүй хугацаа хэтэрсэн зээл 1 дүгээр улирлын байдлаар 1.4 тэрбум болж, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.7 хувийг эзэлж байна.




Зураг.ИИ.1. Зээлийн өрийн үлдэгдэл, хадгаламжийн үлдэгдэл, тэрбум.төг



Даатгал: Орон нутагт үйл ажиллагаагаа явуулж буй даатгалын байгууллагуудын хураамжийн орлого 259.1 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 217.2 (6.2 дахин) сая төгрөгөөр өссөн байна.

Нөхөн төлбөр 629 иргэнд 88.3 сая төгрөг олгосны дотор авто тээврийн хэрэгсэлд 17.0 сая, жолоочийн хариуцлагад 42.7 сая, иргэдийн эд хөрөнгөнд 60.0 мянга, гэнэтийн осолд 3.2 сая, хөдөлмөрийн чадвар түр алдалт 25.0 сая, хурдан морь унаач хүүхдийн даатгалд 0.3 сая төгрөгийг тус тус олгожээ.

Зураг.ИИ.1.2 Даатгалын төрлөөр




II.2 Төрийн санхүү:

Аймгийн төсвийн нийт орлого эхний улирлын байдлаар 20.8 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 3.4 (19.4%) тэрбум төгрөгөөр, төсвийн зарлага санхүүжилт 17.5 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1.7 (10.8%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Аймгийн нийт төсвийн 12.2 хувийг орон иутгийн төсвийн орлого, 10.8 хувийг улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, 7.3 хувийг аймгаас авсан санхүүгийн дэмжлэг, 10.2 хувийг орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг, 57.6 хувийг урьд оны үлдэгдэл, 1.9 хувийг төсөвт байгууллагуудын өөрийн орлого тус тус эзэлж байна.

Зураг.II.2. Төсвийн орлого, зарлага, тэрбум.төг




II.3 Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2022 оны 3 дугаар сард өмнөх сараас 0.6 хувь, өмнөх оны мөн үеэс 14.2 хувь, жилийн эцсээс 4.4 хувиар тус тус өссөн.

Зураг.II.4.1 Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны 12 сар=100)





Ерөнхий индекс жилийн эцсээс 4.4 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 5.5 хувь, хувцас бөс барааны бүлгийн үнэ 1.7 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш 3.5 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 8.1 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 9.0 хувь, тээврийн бүлгийн үнэ 3.5 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйчилгээний бүлгийн үнэ 1.5 хувь, боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ 2.1 хувь, бусад бараа, үйлчилгээ 8.6 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Хүснэгт. II.4.1 Хэрэглээний үнийн үнийн индекс, бүлгээр

| Бараа үйлчилгээний бүлэг | $\frac{2022.III}{2021.III}$ | $\frac{2022.III}{2021.XII}$ | $\frac{2022.III}{2021.II}$ |
|---|-----------------------------|-----------------------------|----------------------------|
| Ерөнхий индекс | 114.2 | 104.4 | 100.6 |
| Хүнсний бараа, согтууруулах бус ундаа | 115.9 | 105.4 | 100.8 |
| Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис | 103.3 | 99.9 | 100.0 |
| Хувцас, бөс бараа, гутал | 112.3 | 101.7 | 100.0 |
| Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш | 112.9 | 103.5 | 100.0 |
| Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа | 118.3 | 108.1 | 100.0 |
| Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ | 116.9 | 109.0 | 100.6 |
| Тээвэр | 121.1 | 103.5 | 101.9 |
| Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ | 100.0 | 100.0 | 100.0 |
| Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ | 102.3 | 101.5 | 100.0 |
| Боловсролын үйлчилгээ | 103.5 | 102.1 | 100.0 |
| Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ | 103.2 | 100.0 | 100.0 |
| Бусад бараа, үйлчилгээ | 113.6 | 108.6 | 101.0 |



II.4 Хөдөө аж ахуй

Мал төллөлт төл бойжилт: Оны эхний төллөх насны хээлтэгч малын 350.5 (18.7%) мянган хээлтэгч мал төллөсөн. Таван төрлөөр нь авч үзвэл: эм хонь 22.4%, эм ямаа 17.8%, үнээ 7.1%, ингэ 5.6%, гүү 4.2% тус тус төллөжээ.

Гарсан төлийн 349.5 (99.6%) мянган төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 103.4 (42.0%) мянгаар өссөн байна.


3 дугаар сарын байдлаар төл бойжилтыг төрлөөр нь авч үзвэл: хурга 99.7%, тугал 99.7%, унага 99.5%, ботго 99.4%, ишиг 99.3% байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.2 пунктээр өссөн байна.



Малын онд оролт: Том малын зүй бус хорогдол эхний 3 сарын байдлаар 3.7 мянган толгой болж, өмнөх оны мөн үеэс 21.4 (85.4%) мянган толгойгоор буурсан. Том малын хорогдлын төрлөөр нь авч үзвэл: тэмээ 5, адуу 326, үхэр 326, хонь 1.5 мянга, ямаа 1.6 мянган толгой байна.

Малын нийт хорогдлын 84.5%-ийг хонь, ямаа эзэлж байна.

Зураг-II.4.3 Том малын зүй бус хорогдол



Эхний 3 сарын байдлаар оны эхний малын 0.1% нь хорогджээ. Аймгийн хэмжээнд 1 дүгээр улиралд өвчнөөр 119 мал хорогдсон нь нийт хорогдлын 3.2%-ийг эзэлж байна.



II.5 Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2010 оны зэрэгцүүлэх үнээр 41.4 тэрбум төгрөг болж өмнөх оноос 10.3 (33.1%) тэрбум төгрөгөөр өсжээ. Ангиллаар нь өмнөх онтой харьцуулан авч үзвэл: уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарынх 8.2 (30.6%) тэрбум төгрөг, боловсруулах аж үйлдвэрийнх 1.6 (89.5%) тэрбум төгрөг, цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарынх 0.5 (20.5%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Оны үнээр 174.9 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үеэс 49.4 (39.4%) тэрбум төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс хүрэн нүүрс, төмрийн хүдрийн баяжмал, түгээсэн цэвэр ус, нарийн боов, хэвийн боов, хийжүүлсэн цэвэр ус, рашаан, монгол дээл, тэрлэг, гэрийн бүрээс туурга бусад хэрэгсэл, модон сандал, блок, вакуум цонх, сувагжуулалт зэрэг нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт өмнөх оны мөн үеэс өссөн байна.



II.6 Тээвэр

Авто тээвэр бүхий байгууллагууд 1 дүгээр улирлын байдлаар 26.6 мян.тн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үеэс 42.7 (61.6%) мян.тн-оор буурсан байна.

Бүтээгдэхүүн тээвэрлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзвэл: цайрын баяжмал 10.5 (69.3%) мян.тн-оор, нүүрс 15.4 (9.4%) мян.тн-оор тус тус буурсан.

Мөн давхардсан тоогоор 1.7 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс зорчигчдын тоо 1.0 (2.4 дахин) мянган хүнээр өсчээ.

Авто тээврийн орлого 0.5 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 2.7 (84.3%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

Т.ЭРДЭНЭБАТ



ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эцсийн байдлаар

| | Хэмжих нэгж | 2020 | 2021 | 2022 | Зөрүү | $\frac{2022}{2021}$ % |
|---|-------------|-----------|-----------|-----------|----------|-----------------------|
| Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд | | | | | | |
| Төрсөн хүүхэд | хүн | 327 | 356 | 230 | -126 | 64.6 |
| Нялхасын эндэгдэл | хүн | 3 | 1 | 2 | 1 | 200.0 |
| Бүртгэлтэй ажилгүй иргэд | хүн | 1 036 | 665 | 532 | -133 | 80.0 |
| Халдварт өвчнөөр өвчдөгчид | хүн | 140 | 137 | 3 458 | 3 321 | 2524.1 |
| Бүртгэгдсэн гэмт хэрэг | тоо | 139 | 109 | 175 | 66 | 160.6 |
| Хэрэгт холбогсод | хүн | 55 | 112 | 20 | -92 | 17.9 |
| Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт | | | | | | |
| Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, оны эцэстэй харьцуулснаар, хувиар | хувь | 102.7 | 101.9 | 111.6 | 9.7 | - |
| Иргэдийн хадгаламж | тэрбум.төг | 88 630.0 | 136 903.8 | 146 795.4 | 9 891.6 | 107.2 |
| Зээлийн өрийн үлдэгдэл | тэрбум.төг | 130 117.7 | 139 993.5 | 192 151.3 | 52 157.8 | 137.3 |
| Орон нутгийн төсвийн орлого | сая.төг | 16 609.8 | 17 376.1 | 20 752.1 | 3 376.0 | 119.4 |
| Орон нутгийн төсвийн зарлага | сая.төг | 14 847.3 | 15 808.6 | 17 518.1 | 1 709.5 | 110.8 |
| Төллөсөн хээлтэгч | тол | 322 888 | 247 089 | 350 484 | 103 395 | 141.8 |
| Ингэ | тол | 321 | 303 | 171 | -132 | 56.4 |
| Гүү | тол | 6 316 | 4 181 | 4 916 | 735 | 117.6 |
| Үнээ | тол | 10 049 | 6 131 | 8 546 | 2 415 | 139.4 |
| Эм хонь | тол | 211 134 | 162 090 | 229 296 | 67 206 | 141.5 |
| Эм ямаа | тол | 95 068 | 74 384 | 107 555 | 33 171 | 144.6 |
| Бойжуулсан төл | тол | 321 146 | 246 090 | 349 543 | 103 453 | 142.0 |
| Ботго | тол | 319 | 301 | 170 | -131 | 56.5 |
| Унага | тол | 6 159 | 4 142 | 4 892 | 750 | 118.1 |
| Тугал | тол | 9 893 | 6 062 | 8 517 | 2 455 | 140.5 |
| Хурга | тол | 210 358 | 161 589 | 228 806 | 67 217 | 141.6 |
| Ишиг | тол | 94 417 | 73 996 | 107 158 | 33 162 | 144.8 |
| Том малын зүй бусын хорогдол | тол | 15 034 | 25 046 | 3 664 | -21 382 | 14.6 |
| Тэмээ | тол | 5 | 8 | 5 | -3 | 62.5 |
| Адуу | тол | 524 | 757 | 236 | -521 | 31.2 |
| Үхэр | тол | 1 383 | 1 994 | 326 | -1 668 | 16.3 |
| Хонь | тол | 6 351 | 10 263 | 1 485 | -8 778 | 14.5 |
| Ямаа | тол | 6 771 | 12 024 | 1 612 | -10 412 | 13.4 |
| Үүнээс: Өвчнөөр хорогдсон мал | тол | 103 | - | 119 | -119 | - |
| Тэмээ | тол | - | - | - | - | - |
| Адуу | тол | 1 | - | - | - | - |
| Үхэр | тол | 3 | - | 21 | -21 | - |
| Хонь | тол | 46 | - | 45 | -45 | - |
| Ямаа | тол | 53 | - | 53 | -53 | - |
| Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн | сая.төг | 10 068.1 | 11 215.2 | 12 973.7 | 1 758.5 | 115.7 |
| Борлуулсан бүтээгдэхүүн | сая.төг | 33 907.9 | 28 735.4 | 25 948.2 | -2 787.2 | 90.3 |

**I.1.1 ХӨДӨЛМӨР****I.1.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, СУМААР**

| Сум | 2020 | | 2021 | | 2022 | $\frac{2022.III}{2021.III}$ % |
|--------------|------|-----|------|-----|------|-------------------------------|
| | III | XII | III | XII | III | |
| Асгат | 6 | 10 | 2 | 8 | 3 | 150.0 |
| Баяндэлгэр | 39 | 9 | 21 | 51 | 11 | 52.4 |
| Дарьганга | 46 | 35 | 28 | 34 | 17 | 60.7 |
| Мөнххаан | 65 | 7 | 5 | 38 | 8 | 160.0 |
| Наран | 40 | 28 | 12 | 6 | 6 | 50.0 |
| Онгон | 32 | 11 | 15 | 37 | 30 | 200.0 |
| Сүхбаатар | 68 | 55 | 42 | 48 | 8 | 19.0 |
| Түвшинширээ | 60 | 57 | 54 | 83 | 48 | 88.9 |
| Түмэнцогт | 44 | 20 | 17 | 30 | 22 | 129.4 |
| Уулбаян | 83 | 32 | 36 | 10 | 7 | 19.4 |
| Халзан | 23 | 4 | - | 15 | 10 | - |
| Эрдэнэцагаан | 39 | 50 | 50 | 32 | 19 | 38.0 |
| Баруун-Урт | 142 | 144 | 195 | 171 | 241 | 123.6 |
| Дүн | 687 | 462 | 477 | 563 | 430 | 90.1 |

I.1.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, СУМААР, БОЛОВСРОЛ, НАСНЫ БҮЛГЭЭР

| Сум | Бүгд | эмэгтэй | Боловсролын түвшингээр | | | | | | | | | Насны бүлгээр | | | | | |
|--------------|------|---------|------------------------|----------------------|-----------------------------|---------------------------|----------------------------|-------|------|--------------|-------|---------------|-------|-------|-------|-----|--|
| | | | Магистр, доктор | Дээд боловсролтой | Тусгай дунд боловсролтой | Мэргэжлийн анхан шатны | Бүрэн дунд боловсролтой | Суурь | Бага | Боловсролгүй | 15-24 | 25-34 | 35-44 | 45-54 | 55-59 | 60+ | |
| | | | | | | | | | | | | | | | | | |
| Асгат | 3 | 2 | - | - | - | - | 3 | - | - | - | 2 | - | 1 | - | - | - | |
| Баяндэлгэр | 11 | 7 | - | 1 | - | 1 | 9 | - | - | - | 2 | 5 | 2 | 2 | - | - | |
| Дарьганга | 17 | 23 | - | 2 | - | 3 | 8 | 4 | - | - | 5 | 6 | 2 | 3 | 1 | - | |
| Мөнххаан | 8 | 5 | - | 3 | - | - | 5 | - | - | - | - | 4 | 2 | 2 | - | - | |
| Наран | 6 | 9 | - | 1 | - | - | - | 4 | - | 1 | - | 1 | 5 | - | - | - | |
| Онгон | 30 | 11 | - | 4 | - | - | 21 | 5 | - | - | 5 | 7 | 8 | 7 | 3 | - | |
| Сүхбаатар | 8 | 4 | - | 4 | - | 1 | 2 | 1 | - | - | 2 | 3 | 1 | 1 | 1 | - | |
| Түвшинширээ | 48 | 24 | - | 6 | 3 | 3 | 16 | 13 | 7 | - | 7 | 20 | 14 | 5 | 2 | - | |
| Түмэнцогт | 22 | 10 | - | 4 | - | - | 17 | 1 | - | - | 1 | 8 | 5 | 5 | 2 | 1 | |
| Уулбаян | 7 | 5 | - | 2 | - | - | 1 | 2 | 1 | 1 | - | 3 | 4 | - | - | - | |
| Халзан | 10 | 7 | - | - | - | - | 9 | - | 1 | - | 3 | 2 | 2 | 3 | - | - | |
| Эрдэнэцагаан | 19 | 10 | - | 4 | 1 | 1 | 11 | 2 | - | - | 7 | 3 | 6 | 2 | 1 | - | |
| Баруун-Урт | 241 | 103 | 1 | 38 | 7 | 16 | 145 | 23 | 8 | 3 | 31 | 78 | 83 | 44 | 4 | 1 | |
| Дүн | 430 | 220 | 1 | 69 | 11 | 25 | 247 | 55 | 17 | 5 | 65 | 140 | 135 | 74 | 14 | 2 | |



I.1.3 ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар

| Сум | 2020 | | 2021 | | 2022 | 2022.I-III 2021.I-III % |
|--------------|------------|--------------|------------|--------------|------------|----------------------------|
| | I-III | I-XI | I-III | I-XI | I-III | |
| Асгат | 7 | 30 | 3 | 95 | 5 | 166.7 |
| Баяндэлгэр | 75 | 156 | 25 | 193 | - | - |
| Дарьганга | 3 | 55 | 7 | 177 | 33 | 471.4 |
| Мөнххаан | 44 | 184 | - | 96 | 3 | - |
| Наран | 9 | 118 | 12 | 98 | 14 | 116.7 |
| Онгон | 21 | 122 | - | 141 | 2 | - |
| Сүхбаатар | 21 | 157 | 3 | 122 | 6 | 200.0 |
| Түвшинширээ | 26 | 228 | 6 | 258 | 13 | 216.7 |
| Түмэнцогт | 37 | 137 | 7 | 125 | 8 | 114.3 |
| Уулбаян | 45 | 158 | 6 | 124 | 1 | 16.7 |
| Халзан | 16 | 41 | 2 | 39 | 3 | 150.0 |
| Эрдэнэцагаан | 36 | 110 | 4 | 103 | 11 | 2.7* |
| Баруун-Урт | 130 | 783 | 134 | 1 018 | 152 | 113.4 |
| Дүн | 470 | 2 279 | 209 | 2 589 | 251 | 120.1 |

I.1.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АЖИЛД ОРСОН ХҮНИЙ ТОО, сумаар

| Сум | 2020 | | 2021 | | 2022 | 2022.III 2021.III % |
|--------------|------------|------------|-----------|------------|-----------|------------------------|
| | III | I-XII | III | I-XII | III | |
| Асгат | 3 | 9 | 1 | 52 | 2 | 200.0 |
| Баяндэлгэр | 28 | 65 | - | 35 | - | - |
| Дарьганга | 3 | 37 | - | 30 | - | - |
| Мөнххаан | 8 | 51 | - | 29 | 1 | - |
| Наран | 5 | 79 | 12 | 52 | 2 | 16.7 |
| Онгон | - | 43 | - | 49 | - | - |
| Сүхбаатар | 11 | 110 | 1 | 21 | - | - |
| Түвшинширээ | 3 | 69 | 4 | 81 | 9 | 225.0 |
| Түмэнцогт | 1 | 33 | - | 43 | 2 | - |
| Уулбаян | 36 | 52 | - | 37 | 0 | - |
| Халзан | 4 | 17 | - | 10 | 1 | - |
| Эрдэнэцагаан | 1 | 9 | - | 7 | 1 | - |
| Баруун-Урт | 6 | 272 | 42 | 161 | 4 | 9.5 |
| Дүн | 109 | 846 | 63 | 607 | 22 | 34.9 |



I.1.5 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮНИЙ ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

| Сум | Шинэ ажлын байранд орсон хүний тоо | | Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар | | | | | | | | | | | | | | | | |
|--------------|------------------------------------|------------|---|-----------------------|-------------------------|--|---------|--|-----------------------------------|---|-----------------|--------------------------------|--------------------------|--|---|-----------|--|------------------------------|----------------------------------|
| | | | Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур | Уул уурхай, олборлолт | Боловсруулах аж үйлдвэр | Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент | Барилга | Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ | Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа | Мэдээлэл холбоо | Санхүү даатгалын үйл ажиллагаа | Мэргэжлийн шинжлэх ухаан | Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа | Төрийн удирдлага ба оатлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалад | Боловсрол | Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа | Урлаг, үзвэр, тоглоом наадам | Үйлчилгээний бусад үйл ажиллагаа |
| | 2021 I-III | 2022.I-III | | | | | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | Байнгын | Түр | Улирал | | | | | | | | | | | | | | | |
| Асгат | 1 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | |
| Баяндэлгэр | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | |
| Дарьганга | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | |
| Мөнххаан | 2 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | |
| Наран | 1 | 2 | 2 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | 2 | |
| Онгон | 2 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | |
| Сүхбаатар | 1 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | |
| Түвшинширээ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | |
| Түмэнцогт | 2 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | |
| Уулбаян | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | |
| Халзан | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | |
| Эрдэнэцагаан | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | |
| Баруун-Урт | 11 | 1 | 1 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | 1 | |
| Дүн | 20 | 3 | 3 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | 3 | |

**I.2 НИЙГМИЙН ДААТГАЛ, НИЙГМИЙН ХАЛАМЖ****I.2.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ, сумаар, сая.төг**

| Сум | Нийгмийн даатгалын шимтгэл | | | | Сайн дурын даатгалын шимтгэлийн орлого | | | |
|--------------|----------------------------|------------|---------|-------|--|------------|-------|-------|
| | 2021.I-III | 2022.I-III | | | 2021.I-III | 2022.I-III | | |
| | | Төл | Гүйц | % | | Төл | Гүйц | % |
| Асгат | 48.6 | 66.6 | 69.6 | 104.5 | 12.5 | 16.7 | 17.8 | 106.6 |
| Баяндэлгэр | 136.7 | 133.3 | 143.1 | 107.4 | 25.5 | 39.0 | 39.9 | 102.3 |
| Дарьганга | 95.9 | 95.3 | 109.7 | 115.1 | 13.5 | 30.7 | 26.7 | 87.0 |
| Мөнххаан | 112.2 | 117.1 | 119.8 | 102.3 | 25.0 | 39.0 | 30.9 | 79.2 |
| Наран | 50.7 | 59.1 | 57.2 | 96.8 | 10.1 | 20.9 | 14.5 | 69.4 |
| Онгон | 173.8 | 128.5 | 171.2 | 133.2 | 16.9 | 34.9 | 25.0 | 71.6 |
| Сүхбаатар | 97.4 | 105.3 | 99.8 | 94.8 | 22.5 | 32.1 | 33.3 | 103.7 |
| Түвшинширээ | 89.1 | 90.4 | 106.1 | 117.4 | 15.4 | 27.9 | 19.6 | 70.3 |
| Түмэнцогт | 77.4 | 167.4 | 127.6 | 76.2 | 9.7 | 18.1 | 16.9 | 93.4 |
| Уулбаян | 94.4 | 161.1 | 132.1 | 82.0 | 8.5 | 20.9 | 15.1 | 72.2 |
| Халзан | 71.6 | 63.4 | 69.4 | 109.5 | 5.5 | 13.9 | 12.1 | 87.1 |
| Эрдэнэцагаан | 244.7 | 218.7 | 244.3 | 111.7 | 39.1 | 62.8 | 55.8 | 88.9 |
| Баруун-Урт | 2 465.2 | 2 674.0 | 2 770.9 | 103.6 | 73.9 | 129.1 | 108.5 | 84.0 |
| Дүн | 3 757.7 | 4 080.2 | 4 220.8 | 103.4 | 278.1 | 486.0 | 416.1 | 85.6 |

I.2.2 ТЭТГЭВЭР ОЛГОЛТ, сумаар

| Сум | Тэтгэвэр авагчдын тоо | | | | Олгосон тэтгэвэр, сая.төг | | | |
|--------------|-----------------------|------------|------------|-------|---------------------------|------------|------------|-------|
| | 2020.I-III | 2021.I-III | 2022.I-III | % | 2020.I-III | 2021.I-III | 2022.I-III | % |
| Асгат | 283 | 309 | 323 | 104.5 | 289.9 | 334.6 | 432.8 | 129.3 |
| Баяндэлгэр | 624 | 727 | 734 | 101.0 | 697.1 | 789.3 | 974.9 | 123.5 |
| Дарьганга | 370 | 462 | 474 | 102.6 | 396.2 | 489.5 | 626.8 | 128.0 |
| Мөнххаан | 529 | 579 | 602 | 104.0 | 551.8 | 619.8 | 802.7 | 129.5 |
| Наран | 194 | 246 | 276 | 112.2 | 237.6 | 274.9 | 372.5 | 135.5 |
| Онгон | 511 | 547 | 571 | 104.4 | 588.7 | 662.0 | 810.8 | 122.5 |
| Сүхбаатар | 388 | 422 | 464 | 110.0 | 403.2 | 458.5 | 606.3 | 132.2 |
| Түвшинширээ | 392 | 422 | 426 | 100.9 | 401.4 | 433.2 | 559.1 | 129.1 |
| Түмэнцогт | 371 | 393 | 415 | 105.6 | 393.2 | 428.7 | 557.7 | 130.1 |
| Уулбаян | 396 | 450 | 472 | 104.9 | 424.5 | 477.8 | 629.6 | 131.8 |
| Халзан | 204 | 241 | 264 | 109.5 | 213.5 | 261.6 | 349.2 | 133.5 |
| Эрдэнэцагаан | 782 | 962 | 906 | 94.2 | 916.4 | 1 004.9 | 1 291.7 | 128.5 |
| Баруун-Урт | 3 086 | 3 331 | 3 386 | 101.7 | 3 604.9 | 3 935.2 | 11 225.6 | 285.3 |
| Дүн | 8 130 | 9 091 | 9 313 | 102.4 | 9 118.4 | 10 170.0 | 19 239.7 | 189.2 |



I.2.3 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, сая.төг

| Үзүүлэлт | | 2021.I-III | | 2022.I-III | | |
|--|---|--|---------------|----------------|----------------|-------|
| | | Хүн тоо | сая.төг | Хүн тоо | сая.төг | |
| Улсын төсөөс | 1 Халамжийн тэтгэвэр | 1 246 | 729.7 | 1 156 | 1 088.3 | |
| | 2 Халамжийн тэтгэмж | 1 267 | 345.6 | 1 863 | 524.4 | |
| | 1. Асаргааны тэтгэмж | 990 | 236.1 | 944 | 276.6 | |
| | байнгын асаргаа шаардлагатай | Ахмад настныг асарч байгаа иргэд олгох тэтгэмж | 558 | 92.3 | 488 | 132.1 |
| | | Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж | 193 | 104.5 | 183 | 51.7 |
| | | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж | 204 | 33.2 | 234 | 79.9 |
| | Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгалзан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж | 14 | 2.2 | 14 | 4.6 | |
| | Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж | 7 | 1.6 | 7 | 2.5 | |
| | Хүүхэд, төрөл садангүй ганц бие ахмад настан болон ХБ иргэнийг гэр бүлдээ авч асран хамгаалах | 14 | 2.3 | 18 | 5.8 | |
| | 3 Хүнс тэжээлийн хөтөлбөрийн зардал | 5 739 | 139.7 | 3 078 | 68.2 | |
| | 4 Ахмад настны нийгмийн хамгаалалын тухай хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт тусламж | 4 150 | 52.6 | 4 275 | 57.0 | |
| | 5 Алдар цолтой ахмадуудад олгосон хөнгөлөлт тусламж | - | - | 2 | 0.3 | |
| | 6 ХБ-тэй иргэнд олгогдож буй хөнгөлөлт, тусламж | 237 | 21.5 | 146 | 26.9 | |
| | 7 Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж | 3 804 | 370.4 | 4 117 | 610.4 | |
| | 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж | 3 190 | 315.2 | 3 396 | 492.9 | |
| | Жирэмсэн эхийн тэтгэмж | 609 | 45.2 | 581 | 52.7 | |
| Ихэр хүүхдийн тэтгэмж | 5 | 10.0 | 5 | 10.0 | | |
| 3 ба түүнээс дээш тооны хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт жилд 1 удаа | - | - | 135 | 54.8 | | |
| 8 Насны хишиг | 2 670 | 215.7 | 2 836 | 223.8 | | |
| 9 Алдарт эхийн одонтой эхчүүдэд олгосон тусламж | 5 219 | 696.5 | 5 347 | 704.5 | | |
| Халамжийн сангаас | 1 Амжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж | 277 | 109.5 | 919 | 247.8 | |
| | Байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэн | 84 | 5.0 | 671 | 40.3 | |
| | 16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж | 193 | 104.5 | 234 | 190.7 | |
| | 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн | - | - | 5 | 6 | |
| | Гэнэтийн аюулын улмаас орон гэргүй болсон өрхөд 1 удаа олгох тэтгэмж | - | - | 6 | 7.2 | |
| | Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн | - | - | 3 | 3.6 | |
| | 2 Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ | - | - | - | - | |
| ДҮН | 24 609 | 2 681.2 | 22 820 | 3 303.8 | | |

**I.3 ЭРҮҮЛ МЭНД****I.3.1 ЭРҮҮЛ МЭНД**

| | Хэмжих нэгж | 2021.I-III | 2022.I-III | Өсөлт | |
|-------------------------------------|-------------|------------|------------|-------|-------|
| | | | | тоо | % |
| 1. Нийт үзлэг | мян.хүн | 56.9 | 58.6 | 1.7 | 103.0 |
| 2. Ор хоног | мян.хүн | 22.4 | 33.5 | 11.1 | 149.6 |
| 3. Урьдчилан сэргийлэх үзлэг | мян.хүн | 15.9 | 11.4 | -4.5 | 71.7 |
| 4. Эмчлүүлсэн хүний тоо | мян.хүн | 2.8 | 4.1 | 1.3 | 146.4 |
| 5. Түргэн тусламжийн дуудлага | мян.хүн | 3.5 | 4.4 | 0.9 | 125.7 |
| Үүнээс: алсын дуудлага | мян.хүн | 0.8 | 0.8 | 0 | 100.0 |
| 6. Осол гэмтлийн дуудлага | хүн | 73 | 67 | -6 | 91.8 |
| Нийт нас баралт | хүн | 86 | 76 | -10 | 88.4 |
| 8. Амаржсан эх | хүн | 354 | 230 | -124 | 65.0 |
| Үүнээс: амьд төрсөн хүүхэд | хүн | 356 | 230 | -126 | 64.6 |
| 9. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд | хүн | 1 | 2 | 1 | 200.0 |
| 10. 1-5 хүртэлх насны эндсэн хүүхэд | хүн | 1 | 3 | 2 | 3.0* |

I.3.2 ТӨРӨЛТ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар

| Сум | Амаржсан эх | Амьд төрсөн хүүхэд | 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд | 1-5 хүртэл насны эндсэн хүүхэд |
|--------------|-------------|--------------------|---------------------------------|--------------------------------|
| Асгат | - | - | 1 | - |
| Баяндэлгэр | 1 | 1 | - | - |
| Дарьганга | - | - | - | - |
| Мөнххаан | - | - | - | - |
| Наран | - | - | - | - |
| Онгон | 3 | 3 | - | 1 |
| Сүхбаатар | - | - | - | - |
| Түвшинширээ | - | - | - | - |
| Түмэнцогт | 1 | 1 | - | - |
| Уулбаян | - | - | - | - |
| Халзан | - | - | - | - |
| Эрдэнэцагаан | 6 | 6 | - | - |
| Баруун-Урт | 219 | 219 | 1 | 2 |
| Дүн | 230 | 230 | 2 | 3 |



I.3.3 ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ГАРАЛТ

| Халдварт өвчин | Хэмжих нэгж | 2021.I-III | 2022.I-III | Өсөлт | |
|--------------------|-------------|------------|------------|-------|--------|
| | | | | Тоо | Хувь |
| Вируст гепатит | хүн | 3 | 2 | -1 | 67 |
| Гар хөл амны өвчин | хүн | 19 | 1 | -18 | 5 |
| Бруцеллёз | хүн | - | 1 | - | - |
| Цусан суулга | хүн | 12 | 1 | -11 | 8.3 |
| Салхинцэцэг | хүн | 3 | 4 | 1 | 133.3 |
| Сүрьеэ | хүн | 14 | 19 | 5 | 135.7 |
| Тэмбүү | хүн | 23 | 8 | -15 | 34.8 |
| Трихоминиаз | хүн | 28 | 19 | -9 | 67.9 |
| Заг | хүн | 24 | 8 | -16 | 33.3 |
| Ковид-19 | хүн | 11 | 3 395 | 3 384 | 308.6* |
| Бүгд | хүн | 137 | 3 458 | 3 321 | 25.2* |

I.3.4 ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧДИЙН ТОО, СУМААР

| Сум | Халдвар өвчнөөр өвчлөгчид бүгд | | | Вируст гепатит | Гар хөл амны өвчин | Цусан суулга | Салхинцэцэг | Сүрьеэ | Тэмбүү | Заг | Трихоминиаз | Ковид-19 |
|--------------|--------------------------------|------------|-----------------|----------------|--------------------|--------------|-------------|--------|--------|-----|-------------|----------|
| | 2021.I-III | 2022.I-III | 1000 хүн тутамд | | | | | | | | | |
| Асгат | 8 | 138 | 71 | 1 | - | - | - | 1 | 1 | - | - | - |
| Баяндэлгэр | 7 | 345 | 68 | - | - | - | - | 3 | - | 1 | - | 1 |
| Дарьганга | 2 | 67 | 21 | - | - | - | - | - | - | - | 2 | - |
| Мөнххаан | 17 | 143 | 29 | - | - | - | - | - | - | - | - | - |
| Наран | 3 | 24 | 14 | - | - | - | - | - | - | - | - | - |
| Онгон | 3 | 160 | 41 | - | - | - | - | - | - | - | - | - |
| Сүхбаатар | 5 | 93 | 27 | - | - | - | - | 1 | - | 3 | 1 | - |
| Түвшинширээ | 5 | 41 | 12 | - | - | - | - | - | - | - | - | - |
| Түмэнцогт | 2 | 44 | 18 | - | - | - | - | 1 | - | - | - | - |
| Уулбаян | - | 89 | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Халзан | 4 | 139 | 76 | - | - | - | 1 | - | 1 | - | - | - |
| Эрдэнэцагаан | 5 | 82 | 12 | - | - | - | - | 3 | - | 1 | 3 | - |
| Баруун-Урт | 76 | 2 093 | 93 | 1 | 1 | 1 | 3 | 10 | 6 | 3 | 13 | - |
| Дүн | 137 | 3 458 | 54 | 2 | 1 | 1 | 4 | 19 | 8 | 8 | 19 | 1 |

**I.4 СОЁЛ, УРЛАГ****I.4.1 МЭРГЭЖЛИЙН УРЛАГЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЗҮҮЛЭЛТ**

| Он | Нийт тоглолт | Үзэгчид, мян.хүн | Орлого, мян.төг |
|------------|--------------|---------------------|-----------------|
| 2019.I-III | 11 | 2.6 | 1 700.0 |
| 2020.I-III | 2 | 0.8 | 802.0 |
| 2021.I-III | 4 | 0.6 | 1 000.0 |
| 2022.I-III | 8 | 2.9 | 3 534.6 |

I.4.2 МУЗЕЙН ҮЗҮҮЛЭЛТ

| Он | Нийт үзмэрийн тоо | Үзэгчид, мян.хүн | Орлого, мян.төг |
|------------|----------------------|------------------|-----------------|
| 2019.I-III | 2 110 | 0.6 | 291.5 |
| 2020.I-III | 2 110 | 0.0 | 62.0 |
| 2021.I-III | 2 268 | - | - |
| 2022.I-III | 2 297 | 1.2 | 0.8 |

I.4.3 НОМЫН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

| Он | Нийт номын тоо | Уншигчид, мян.хүн |
|------------|----------------|-------------------|
| 2019.I-III | 46 810 | 1.7 |
| 2020.I-III | 47 097 | 0.9 |
| 2021.I-III | 48 814 | 0.7 |
| 2022.I-III | 49 150 | 1.4 |

**I.5 ГАЗАР ӨМЧЛӨЛ****I.5.1 ГАЗАР ӨМЧЛӨЛ, сумаар**

| Сум | Газар өмчлөх өргөдөл гаргасан иргэдийн тоо | | | | Засаг даргын шийдвэр гарсан иргэдийн тоо | | | | Өмчлүүлсэн нийт газар. га | | | |
|-----|--|--------------------|---------------------|--------------------|--|--------------------|---------------------|--------------------|---------------------------|--------------------|---------------------|--------------------|
| | Өссөн дүнгээр | | Үүнээс: 2022. I-III | | Өссөн дүнгээр | | Үүнээс: 2022. I-III | | Өссөн дүнгээр | | Үүнээс: 2022. I-III | |
| | Бүгд | Үүнээс: Шинэ газар | Бүгд | Үүнээс: Шинэ газар | Бүгд | Үүнээс: Шинэ газар | Бүгд | Үүнээс: Шинэ газар | Бүгд | Үүнээс: Шинэ газар | Бүгд | Үүнээс: Шинэ газар |
| Ас | 300 | 235 | - | - | 269 | 216 | - | - | 30.87 | 24.24 | - | - |
| Бд | 903 | 728 | - | - | 777 | 602 | - | - | 58.00 | 43.53 | - | - |
| Да | 410 | 342 | - | - | 381 | 320 | - | - | 34.77 | 28.7 | - | - |
| Мх | 1149 | 983 | - | - | 986 | 815 | - | - | 93.02 | 75.82 | - | - |
| На | 269 | 230 | - | - | 235 | 196 | - | - | 18.86 | 16.08 | - | - |
| Он | 722 | 593 | - | - | 653 | 521 | - | - | 53 | 39.37 | - | - |
| Сү | 464 | 351 | - | - | 421 | 308 | - | - | 38.71 | 28.77 | - | - |
| Тш | 517 | 392 | - | - | 514 | 389 | - | - | 52.07 | 39.07 | - | - |
| Тц | 779 | 550 | - | - | 713 | 531 | - | - | 117.72 | 95.88 | - | - |
| Уб | 440 | 308 | - | - | 416 | 298 | - | - | 31.43 | 21.2 | - | - |
| Ха | 228 | 120 | - | - | 208 | 106 | - | - | 18.82 | 8.38 | - | - |
| Эц | 1 523 | 1 221 | - | - | 1 378 | 1 082 | - | - | 142.85 | 110.04 | - | - |
| Бу | 4 168 | 3 173 | - | - | 4 017 | 3 073 | - | - | 300.29 | 212.61 | - | - |
